



МОНГОЛ УЛС
СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 09 өдөр

Дугаар А/709

Баруун-Урт сум

Орон тооны бус зөвлөл шинэчлэн
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1, 35.1.4 дэх заалт, Шадар сайдын 2017 оны 78 дугаар тушаалаар батлагдсан "Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох, паспортжуулах журам"-ийн дөрөвдүгээр зүйлийн 4.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Барилга байгууламжийн паспортжуулалтын мэргэжлийн дүгнэлт гаргах тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийг сонгон шалгаруулах, мэргэжил арга зүйн удирдлага, баталгаажсан багаж тоног төхөөрөмж, техникээр хангах, техникийн асуудлыг хэлэлцэх, шийдвэр гаргах, мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг доорх бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай.

Комиссын дарга:	Д.Шижирбаатар	Засаг даргын орлогч
Гишүүд:	Б.Алтансүх	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга
	С.Наранчулуун	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилга, хот байгуулалтын хэлтсийн барилгын асуудал хариуцсан мэргэжилтэн
	Э.Батчулуун	Барилгачдын холбооны тэргүүн
	Б.Ганбаяр	Шарга ХХК-ний захирал
	Ж.Эрдэнэчулуун	Мэргэшсэн инженер
Нарийн бичгийн дарга:	Ж.Батсуурь	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, аймгийн ерөнхий архитектор

2. Барилга байгууламжийг паспортжуулах үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, үйл ажиллагааныхаа тайланг аймгийн Засаг даргад танилцуулж ажиллахыг Орон тооны бус зөвлөл (Д.Шижирбаатар)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2019 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/14 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



М.ИДЭРБАТ